



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар A/19

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1305, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын 2023 оны 3 дугаар сарын 13 – ны өдрийн 03 дугаар хурлын тэмдэглэл, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэсэн хотын стандартын 7 бүлгийн 14 төрлийн баримт бичгийн төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барих, ажлын хороод, намын бүлгүүд болон чуулганы нэгдсэн хурлаар хэлэлцүүлэн батлуулах бэлтгэл ажилд шаардагдах зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 10,226,200.00 (арван сая хоёр зуун хорин зургаан мянга хоёр зуу) төгрөгийн зардлыг (хавсралтад тусгана) Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-д даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

1150500039

1. Үзлж 2023.02.blank